- Засгийн газрын 2022 оны 252 дугаар тогтоолоор "Төрийн албан хаагчид мөнгөн урамшуулал олгох журам"-ын Дөрөв. Төрийн болон орон нутгийн өмчийн цэцэрлэг, ерөнхий боловсролын сургууль, мэргэжлийн боловсрол, сургалтын байгууллагын багш, туслах багш, албан хаагчид олгох улирлын ажлын үр дүнгийн мөнгөн урамшуулал" хэсэгт өөрчлөлт оруулан 4.4.2-т ерөнхий боловсролын сургуулийн багшид мөнгөн урамшуулал олгох шалгуур, үзүүлэлтийг тогтоосон.
- БШУС-ын 2022 оны А/122 дугаар тушаалаар Засгийн газрын 2022 оны 91 дүгээр тогтоолыг үндэслэн төрийн болон орон нутгийн өмчит сургуулийн өмнөх болон ерөнхий боловсролын сургуулийн үйлчилгээний албан тушаал эрхэлдэг төрийн зарим албан хаагчийн цалингийн хэмжээг тогтоосон.
- БШУС-ын 2022 оны А/170 дугаар тушаалаар "төрийн болон орон нутгийн өмчийн ерөнхий боловсролын сургууль, цэцэрлэгийн хичээл сургалтын үйл ажиллагааны зардлыг төлөвлөх хуваарилах заавар"-ыг 1 дүгээр, "багшийн тасралтгүй хөгжлийг дэмжих, үйл ажиллагааны санхүүжилт, түүнийг зарцуулах заавар"-ыг 2 дугаар, "цахим хэрэглээний зардлыг төлөвлөх, хуваарилах заавар"-ыг 3 дугаар, "тоног төхөөрөмжийн нөхөн хангалтын зардлыг төлөвлөх хуваарилах, санхүүжүүлэх заавры 4 дүгээр хавсралтаар тус тус баталсан байна.
- БШУС-ын 2022 оны А/259 дүгээр тушаалаар "Цэцэрлэг, ерөнхий боловсролын багшийг эрүүл мэндийн нэмэлт үзлэг, оношилгоонд хамруулах заавар"-ыг баталсан байна.
- БШУС-ын 2022 оны А/430 дугаар тушаалаар багшийн ажлыг үнэлэх журмыг шинэчлэн баталсан.
- БШУС-ын 2022 оны А/452 дугаар тушаал "Хувьсах зардлын тоног төхөөрөмжийн нөхөн хангалтын тухай"
- БШУС-ын 2022 оны А/465 дугаар тушаал "Ерөнхий боловсролын сургуульд кабинет, лаборатори, цахим сургалтын танхим байгуулах, ашиглах нийтлэг журам"
- БШУС-ын 2022 оны А/500 дугаар тушаалаар төрийн болон орон нутгийн өмчийн цэцэрлэг, ерөнхий боловсролын сургуулийн үйл ажиллагааны гүйцэтгэлийн чанар, үр дүнг үнэлж, үр дүнгийн нэмэлт урамшууллын зардлыг санхүүжүүлэхэд баримтлах чиглэлийг баталсан.

5. Хувь хүний орлогын албан татварын тухай хуулийн 25 дугаар зүйлийн 25.7-д "Суутган төлөгч нь албан татвар төлөгчийн энэ хуулийн 21.1-д заасны дагуу ногдох албан татвар, 23.1-д заасны дагуу эдлэх хөнгөлөлтийг жилийн эцсийн тайлангаар эцэслэн тооцож тайлагнан, холбогдох татварыг төсөвт шилжүүлнэ"
6. Төрийн хэмнэлтийн тухай хуулийг хэрэгжүүлэх зарим арга хэмжээний тухай Монгол Улсын Загийн газрын 2022 оны 5 дугаар сарын 25-ны өдрийн 203 дугаар тогтоол,
7. "Цэцэрлэг, ерөнхий боловсролын сургууль/дотуур байрын хүүхдэд хоол, хүнсний хангамж, үйлчилгээ үзүүлэхэд мөрдөх журам"-ыг батлах тухай Боловсрол шинжлэх ухааны сайдын 2022 оны 02 дугаар сарын 22-ны өдрийн А/59 дүгээр тушаал
8. Албан томилолтын зардлын тариф шинэчлэн батлах тухай Сангийн 2022 оны 6 дугаар сарын 02-ны өдрийн 120 дугаар тушаал.

**Байгууллагын дотоод хяналтын талаар**

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж буй дотоод хяналтаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод аудитын үйл ажиллагаа нь зөвхөн үндсэн үйл ажиллагаанд чиглэгдэж, нягтлан бодох бүртгэл, төсвийн төлөвлөлт, зарцуулалт, шилэн дансны, төсвийн, төрийн болон орон нутгийн өмчийн, төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа ажил үйлчилгээ худалдан авах, төрийн хэмнэлтийн тухай зэрэг хууль тогтоомжийн хэрэгжилтэд хяналт хийдэггүй, санхүүгийн мэргэжлийн ажилтан дотоод хяналтын ажлын хэсгийн бүрэлдэхүүнд томилогдоогүй, ажилтнууд нь дотоод хяналтын талаар сургалтад хамрагдаагүй, дотоод хяналтын талаар зохих мэдлэг эзэмшээгүй, дотоод хяналтын ажиллах журамгүй тул дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилтийг үр нөлөөгүй байна гэж үзлээ.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод аудитораас шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

### 3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Төв аймгийн Батсүмбэр сумын ерөнхий боловсролын сургуулийн 2022 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэж, Төсвийн тухай хуулийн 54 дүгээр зүйлийн 54.4, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 8 дугаар зүйлд заасан иж бүрдлийн дагуу бэлтгэж толилуулсан байна гэж үзлээ.

Харин төсвийн гүйцэтгэлийн тайланг мөнгөн сууриар бэлтгэж, Төсвийн тухай хуулийн 54 дүгээр зүйлийн 54.5-д заасны дагуу иж бүрэн ирүүлсэн.

***Байгууллагын мөрдөж буй нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийн талаар***

Санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаанд мөрдөж буй Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичигт УСНББОУС, хууль, тогтоол, тушаал, заавруудын өөрчлөлтийг тусгаагүй, байгууллагын удирдлагын тушаал шийдвэрээр батлаагүйгээс НБББББ-ийг өөрийн байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохируулан боловсруулах шаардлага тулгарч байна.

### 3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд

Төв аймгийн Батсүмбэр сумын ерөнхий боловсролын сургуулийн 2022 оны санхүүгийн тайланг Сангийн сайдын 2006 оны 388 дугаар тушаалаар баталсан “Төсөвт байгууллагад мөрдөх нягтлан бодох бүртгэлийн дансны заавар”-ын дагуу бэлтгэсэн байна.

Тайлант оны 1 дүгээр сараас 4 дүгээр саруудад тогтмол зардал, үйлчилгээний ажилтнуудын цалин, шимтгэлийг орон нутгийн төсвөөс, бусад зардлуудыг улсын төсвөөс санхүүжүүлж ирснийг, 2022 оны 5 дугаар сараас төсвийн хуваарьт өөрчлөлт оруулан цахилгаан эрчим хүч, халаалт, цэвэр бохир ус, урсгал засварын зардлыг орон нутгийн төсвөөс, бусад зардлыг улсын төсвөөс санхүүжүүлсэн байна.

Тайлант оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 456,665.2 мянган төгрөгөөр буюу 8.3 хувиар өссөн байна.

***Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт***

/мянган төгрөгөөр/

| Үзүүлэлт | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл | Өөрчлөлт |
|---|---|---|---|
| Б | 1 | 2 | 3=2-1 |
| Мөнгөн хөрөнгө | - | 78,166.6 | 78,166.6 |
| Авлага | 461.5 | 82,369.9 | 81,908.4 |
| Бараа материал | 181,940.3 | 143,582.6 | (38,357.7) |
| Үндсэн хөрөнгө | 5,299,361.7 | 5,634,309.6 | 334,947.9 |
| **Нийт хөрөнгө** | **5,481,763.5** | **5,938,428.7** | **456,665.2** |
| Өр төлбөр | - | 46,970.9 | 46,970.9 |
| Засгийн газрын хувь оролцоо /Эздийн өмч/ | 5,481,763.5 | 5,891,457.8 | 409,694.3 |
| **Өр төлбөр ба цэвэр хөрөнгө/өмчийн дүн** | **5,481,763.5** | **5,938,428.7** | **456,665.2** |

Дээрх хүснэгтээс харахад мөнгөн хөрөнгө, авлага, үндсэн хөрөнгө, үндсэн хөрөнгө, өр төлбөр, эздийн өмчийн данс өмнөх оноос нэмэгдэж, бараа материал буурсан үзүүлэлттэй байна. Үүнд:

1. Тайлант онд мөнгөн хөрөнгө дансны үлдэгдэл 78,166.6 мянган төгрөгөөр нэмэгдсэн нь улсын төсвөөс хүлээн авсан санхүүжилтийн зарцуулагдаагүй үлдэгдлийг буцаан төвлөрүүлээгүй нь гол нөлөө үзүүлсэн байна.
2. Авлага дансны үлдэгдэл 81,908.4 мянган төгрөгөөр нэмэгдсэн нь Цахим анги байгуулах тендерт шалгарсан 2 байгууллагад өгсөн нь нөлөөлсөн.
3. Бараа материалын дансны үлдэгдэл 38,357.7 мянган төгрөгөөр буурсан нь 25,014.1 мянган төгрөгийн үнэ төлбөргүй орлого, 399,115.1 мянган төгрөгийн орлого, 462,486.9 мянган төгрөгийн зарлага нөлөөлсөн байна.
4. Үндсэн хөрөнгө өмнөх оноос 334,947.9 мянган төгрөгөөр өссөн нь БЕГ-аас 130,473.1 мянган, БСГ-аас 14,768.6 мянган, БСШУЯ-аас 91,700.0 мянган, Дэлхийн зөн ОНХХ-ээс 1,135.4 мянган, ЗДТГ-аас 10,500.0 мянган, ОНХС-аас 7,500.0 мянган, Хайрхан мандал буян ХХК-иас 58,000.0 мянган, эцэг эхийн зөвлөлөөс 11,209.0 мянган Жайка төслөөс 2,879.2 мянган төгрөгийн үнэ төлбөргүй хөрөнгийг орлогод бүртгэсэн нь нөлөөлсөн байна.
5. Өглөг 46,970.9 мянган төгрөгөөр өссөн нь түлш халаалтын үнэ өмнөх оноос өссөнөөс шалтгаалж дутуу шилжүүлсэн нь шалтгаалсан байна.
6. Засгийн газрын хувь оролцоо дансны үлдэгдэл 409,694.3 мянган төгрөгөөр өссөн нь тайлант оны үр дүн нэмэгдсэнээс шалтгаалсан байна.

### 3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

### 3.5.1 Төсвийн төлөвлөлт

Тус байгууллагын 2022 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг 2,848,858.2 мянган төгрөгөөр тооцон төлөвлөж дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Төсвийн төслийн саналаас 13,546.7 мянган төгрөгөөр нэмэгдүүлж 2,835,311.5 мянган төгрөгөөр төсвийг баталсан байна. Энэ нь Төв аймгийн Батсүмбэр сумын ерөнхий боловсролын сургуулийн төсвийн захирагч төсвийн төслийг бодитой, үндэслэлтэй боловсруулаагүйгээс шалтгаалсан байна.

### 3.5.2 Төсвийн гүйцэтгэл

Тайлант оны батлагдсан төсвийг 13,546.7 мянган төгрөгөөр нэмэгдүүлж тодотгосон байна. Төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 1 хөтөлбөрийн 11 арга хэмжээг

санхүүжүүлэхээр 2,355,952.9 мянган төгрөгийг улсын төсвөөс, 479,358.6 мянган төгрөгийг орон нутгийн төсвөөс, 2,835,311.5 мянган төгрөгийг бүрдүүлэхээр байна.

Гүйцэтгэлээр улсын төсвөөс 2,355,952.9 мянган төгрөгийн, орон нутгийн төсвөөс 203,864.8 мянган төгрөгийн санхүүжилт олгож, 479,358.6 мянган төгрөгийн орлоготой ажилласан байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 2,757,144.9 мянган төгрөг буюу 97,2 хувьтай байгаа нь цалин хөлс болон нэмэгдэл урамшлын зардал 60,215.4 мянган, ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэлийн зардал 4,484.0 мянган, нормативд зардал 3,270.8 мянган, бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр 12,179.2 мянган төгрөгөөр тус тус хэмнэсэн байна.

*Хүснэгт 2. Хөтөлбөр, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл*

/мянган төгрөгөөр/

| д/д | Хөтөлбөр, арга хэмжээ | Төлөвлөгөө | Гүйцэтгэл | Зөрүү | Биелэлт |
|---|---|---|---|---|---|
| | Улсын төсвөөс санхүүжих | | | | |
| 1 | 80226-Байр ашиглалтын үйлчилгээ | 6,569.8 | 6,569.8 | - | 100.0 |
| 2 | 80312-Сургалтын семинар | 3,284.9 | 3,284.7 | (0.2) | 100.0 |
| 3 | 81605-Эрүүл мэндийг дэмжих | 7,555.3 | 7,555.3 | - | 100.0 |
| 4 | 81801-Үдийн цай хөтөлбөр | 160,812.4 | 160,812.4 | - | 100.0 |
| 5 | 81806-Дотуур байрны үйлчилгээ | 231,647.1 | 222,344.5 | (9,302.6) | 96.0 |
| 6 | 91816-Хүүхдэд ээлтэй сургалтын орчин | 80,920.0 | 80,818.3 | (101.7) | 99.9 |
| 7 | 81823-Боловсролын байгууллагын багш | 14,782.0 | 14,782.0 | - | 100.0 |
| 8 | 81834-Боловсролын стандарт, сургалтын | 1,628,856.3 | 1,560,218.9 | (68,637.4) | 95.8 |
| 9 | 81835-Сургалтын хэвийн үйл ажиллагаа | 221,525.1 | 221,400.4 | (124.7) | 99.9 |
| | **Дүн** | **2,355,952.9** | **2,277,786.3** | **(78,166.6)** | **96.7** |
| | Орон нутгийн төсвөөс | | | | |
| 1 | 80111-Төрийн өмчийн барилгын тогтмол зардал | 384,286.7 | 384,286.70 | - | 100.0 |
| 2 | 80112-Нийтлэг үйлчилгээ | 95,071.9 | 95,071.90 | - | 100.0 |
| | **Дүн** | **479,358.6** | **479,358.60** | **-** | **100.0** |
| | **Нийт дүн** | **2,835,311.5** | **2,757,144.9** | **(78,166.6)** | **97.2** |

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

### 3.5.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т "нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна" гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Нэмэлт санхүүжилтийн дансанд 85,159.4 мянган төгрөгийн орлогыг бүрдүүлжээ. Үүнээс: Боловсролын тухай хуулийн 43 дугаар зүйлийн 43.1.3, 43.1.7 дугаар заалтын дагуу нийт 4 багшид хөдөө орон нутагт олон жил тогтвор суурьшилтай ажилласны мөнгөн тэтгэмжид 84,272.0 мянган төгрөгийг, спорт бараанд 887.4 мянган төгрөгийг тус тус зарцуулсан байна.

Нэмэлт төсвийн тайланг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.8-д харуулав.

### 3.5.4 Төсөл хөтөлбөрийн үе шат, хүрэх үр дүн

Тайлант онд Төв аймгийн Батсүмбэр сумын ерөнхий боловсролын сургуульд төсөл хөтөлбөр хэрэгжээгүй байна.

## 4. АУДИТЫН ТАЙЛАН

### 4.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д "Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана." гэж заасны дагуу Төв аймгийн Батсүмбэр сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийгдэх байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав. Мөн байгууллагын үйл ажиллагааг сайжруулах зорилготой холбоотой өгсөн зөвлөмжүүдийг тусгасан болно.

Аудитыг Ихмонгол хөлөг Аудит ХХК-ийн ахлах аудитор Г.Ариунбат, аудитор Д.Буянравжих, О.Эрдэнэчимэг, шинжээч Б.Ган-Эрдэнэ, Т.Оюун, аудитын менежер Б.Батцэцэг, аудиторын туслах З.Ариунцэцэг, Г.Ариунболд нар гүйцэтгэж, чанарын хяналтыг чанарын хяналтын мэргэжилтэн С.Сожидмаа, захирал С.Тунгалаг, Төв аймаг дахь Төрийн аудитын газрын аудитын менежер О.Амаржаргал, Дарга, тэргүүлэх аудитор Ц.Хишигжаргал нар тус тус хэрэгжүүлсэн.

Төв аймгийн Батсүмбэр сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2022 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Ихмонгол хөлөг Аудит ХХК-д 2023 оны 01 дүгээр сарын 25-ны өдрийн 16 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

### 4.2 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр батлагдсан төсвийн гүйцэтгэлийн нийт зардлаар сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэлийг "дунд" гэж үнэллээ.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг Төв аймгийн Батсүмбэр сумын Ерөнхий боловсролын сургуулийн төсвийн гүйцэтгэлийн тайлангийн 2022 батлагдсан төсвийн нийт зардлын 2,923,131.6 мянган төгрөгөөс 1 хувиар буюу 29,231.3 мянган төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 70 хувиар буюу 20,461.9 мянган төгрөгөөр тогтоосныг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

### 4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт

Төрийн хэмнэлтийн тухай хууль хэрэгжиж эхэлсэнтэй холбоотойгоор батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулж, 78,166.6 мянган төгрөгийн хэмнэлт гарган ажилласан байна

### 4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

#### 4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан "Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам"-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Шилэн дансны цахим хуудсыг шалгахад 156 мэдээлэл байршуулахаас 145 мэдээлэл хугацаанд нь байршуулж, 11 мэдээллийг хугацаа хоцроож, Цалингийн

зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий 1 удаагийн 148,265,100.00 төгрөгийн орлогын гүйлгээг 173,356.7 мянган төгрөгөөр буюу 25,091.6 мянган төгрөгөөр илүү, 1 удаагийн 19,560.6 мянган төгрөгийн зарлагын гүйлгээг 21,991.9 мянган төгрөгөөр буюу 2,431.3 мянган төгрөгөөр илүү, 1 удаагийн 46,717.3 мянган төгрөгийн орлогын гүйлгээг 20,717.3 мянган төгрөгөөр буюу 26,000.0 мянган төгрөгөөр дутуу байршуулж, 4 удаагийн 117,752.3 мянган төгрөгийн орлого, 6 удаагийн 120,906.9 мянган төгрөгийн зарлагын гүйлгээг байршуулаагүй, хөрөнгө, мөнгө зарцуулах 19 удаагийн 155,948.9 мянган төгрөгийн шийдвэрийг шилэн дансны цахим хуудсанд байршуулаагүй байна.

Энэ нь Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлийн  6.4.5-д "цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлого, зарлагын мөнгөн гүйлгээг гүйлгээ тус бүрээр, гүйлгээний агуулга, хүлээн авагчийн нэр", Төрийн хэмнэлтийн тухай хуулийн  20 дугаар зүйлийн 20.5-т "Энэ хуулийн 3.1-д заасан этгээд Шилэн дансны тухай хуульд заасан мэдээллийг хугацаанд нь байршуулна." гэж заасантай нийцэхгүй, санхүүгийн тайлагналын нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

***<u>Шийдвэрлэсэн нь</u>***:

Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны 12 дугаар сарын 9-ний өдрийн А/95 дугаар тушаалын хавсралт “Акт албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам”-ын 4.2.1.10-т "Аудитаар илэрсэн алдаа, зөрчил, түүнийг арилгахаар өгсөн зөвлөмжийг хугацаанд нь хэрэгжүүлээгүй бол;" гэж заасныг үндэслэн албан шаардлага хүргүүлэв.

**4.4.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд**

Төв аймгийн Батсүмбэр сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2022 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл нь Монгол Улсын Засгийн газрын 2022 оны 91 дүгээр тогтоолын 4 дүгээр хавсралтаар баталсан “Ерөнхий боловсролын сургууль, сургуулийн өмнөх байгууллагын нэг суралцагчид ногдох хувьсах зардлын дундаж нормативын бүрэлдэхүүн, зардлын зориулалт, арга хэмжээний дэлгэрэнгүй заавар”-д төсвийн зарлагыг эдийн засгийн 2 ангиллаар баталснаас шалтгаалж, Сангийн сайдын 2021 оны 190 дүгээр тушаалаар баталсан “Зардлын эдийн засгийн ангилал ашиглах заавар”, Сангийн сайдын 2006 оны 388 дугаар тушаалын 2 дугаар хавсралт, 2014 оны 5 дугаар тушаалын 5 дугаар хавсралтаар баталсан “Балансын дансны жагсаалт”-ын дагуу тайлагнагдаагүй байна.

***<u>Шийдвэрлэсэн нь</u>***: Төсвийн ерөнхийлөн захирагчид уламжлан шийдвэрлүүлэх зөвлөмж өгөв.

2022 онд хийгдсэн дотоод аудитын үйл ажиллагаа нь зөвхөн сургалтын үйл ажиллагаанд чиглэгдсэн, санхүү, шилэн данс, нягтлан бодох бүртгэл, төсвийн тухай, төрийн болон орон нутгийн өмчийн тухай, төрийн хэмнэлтийн тухай хууль тогтоомжийн хэрэгжилтэд хяналт хийдэггүй, санхүүгийн мэргэжлийн ажилтан дотоод хяналтын ажлын хэсгийн бүрэлдэхүүнд томилогдоогүй, ажилтнууд нь дотоод хяналтын талаар сургалтад хамрагдаагүй, дотоод хяналтын талаар зохих мэдлэг эзэмшээгүй, дотоод хяналтын ажиллах журамгүй байна.

***<u>Шийдвэрлэсэн нь:</u>*** Дотоод хяналтын комисст санхүүгийн мэргэжлийн ажилтан ажиллуулах зөвлөмж өгөв.

Хүүхдийн хоол хүнсний материалаас хэмнэгдсэн төсвийн үлдэгдэл 1,453.7 мянган төгрөгийг нөөцөлсөн байна. Энэ нь Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1.6-д "Нөөцлөх шаардлагатай бараа, материалыг үр ашиггүй удаан хадгалах, шаардлагагүйгээр их хэмжээгээр бараа, материал бэлтгэх, нөөцлөх" гэж заасантай нийцэхгүй, санхүүгийн тайлагналын нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

**Шийдвэрлэсэн нь:** Монгол улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалын хавсралт “Акт албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам”-ын 4.2.1.11-т “Хууль тогтоомж, гэрээ, хэлцэл зөрчсөн алдаа, зөрчлийг таслан зогсоож,

давтан гаргуулахгүй байх үр нөлөөтэй гэж үзсэн бусад нөхцөл байдал" гэж заасны үндэслэн албан шаардлага хүргүүлсэн.

Худалдан авсан хөрөнгө, материалын дүнг, бэлтгэн нийлүүлэгч байгууллагуудын цахим баримтын дүнтэй тулгахад 9 иргэн, байгууллагын 2,901.8 мянган төгрөгөөр илүү, 2 иргэн, байгууллагын 774.4 мянган төгрөгөөр дутуу бүртгэгдсэн байна. Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.4-д "нягтлан бодох бүртгэл хөтлөлт нь энэ хууль болон санхүүгийн бусад хууль тогтоомжид заасан шаардлагад нийцэж байгаа эсэхийг хянах", Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.7-д "анхан шатны баримтын бүрдэлгүй ажил гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно", Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.6-д "Албан татвар суутган төлөгч төлбөрийн баримтыг өөр дүнгээр олгосон, эсхүл төлбөрийн баримт олгохоос татгалзсан бол албан татвар төлөгч энэ талаар татварын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагад, эсхүл харьяа татварын албанд нэн даруй мэдэгдэх үүрэгтэй" гэж заасантай нийцэхгүй, санхүүгийн тайлагналын нийцсэн бөгөөд зохистой байх, иж бүрэн байх, тохиолдсон байх гэсэн батламж мэдэгдлүүдийг хангахгүй байна.

***<u>Шийдвэрлэсэн нь:</u>*** Төлбөрийн цахим баримтыг цаг тухай бүрт нь хяналт хэрэгжүүлж ажиллах.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцээгүй гэж дүгнэлээ.

### 4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

#### 4.5.1 Завсрын аудитын талаар

Төв аймгийн Батсүмбэр сумын ерөнхий боловсролын сургуулийн 2022 оны санхүүгийн үйл ажиллагаанд завсрын аудитыг хийгдээгүй болно.

#### 4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

Өмнөх аудитаар 18,062.4 мянган төгрөгийн алдаа зөрчлөөс, 2 зөвлөмж, 17,475.9 мянган төгрөгийн 1 албан шаардлага, 586.5 мянган төгрөгийн 1 төлбөрийн акт тогтоосныг бүрэн хэрэгжүүлсэн байна.

*Хүснэгт 4 Төлбөрийн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт*

/мянган төгрөгөөр/

| Үзүүлэлт | Өмнөх аудитын үзүүлэлт | | Биелэлт | | |
|---|---|---|---|---|---|
| | Тоо | Дүн | Тоо | Дүн | Хувь |
| Албан шаардлага | 1 | 17,475.9 | 1 | 17,475.9 | 100.0 |
| Зөвлөмж | 2 | - | 2 | - | 100.0 |
| Төлбөрийн акт | 1 | 586.5 | 1 | 586.5 | 100.0 |
| **Нийт дүн** | **4** | **18,062.4** | **4** | **18,062.4** | **100.0** |

### 4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Шалгагдагч байгууллага дээр ажиллаж хөрөнгийн биет тооллого хийх нөхцөл байдал хязгаарлагдмал байснаас биет тест хэрэгжүүлээгүй.

Дараагийн аудитаар төсвийн жил дамжин хэрэгжиж байгаа сургалтын үйл ажиллагаа, хувьсах зардлын нөхөн хангалтаар авч байгаа тоног төхөөрөмж, бараа материалыг орлогод авсан эсэхийг авч үзэх нь зүйтэй гэж үзлээ.

## 5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт 5,647,059.2 мянган төгрөгийн алдаа[1] илэрснээс, аудитын явцад 5,647,059.2 мянган төгрөгийн алдааг залруулсан.

Үүнд: **Залруулсан алдаа:**

- Мөнгөн хөрөнгөнөөс 6 ажил гүйлгээгээр 8,979.5 мянган төгрөгийг шилжүүлэхдээ тооцооны дансаар дамжуулалгүй шууд зардалд бичиж хаасан байна.
- Төсвийн гүйцэтгэлийн тайланд суралцагчдын тоог тайлагнаагүй байна.
- Цалин хөлсний дэлгэрэнгүй бүртгэлийг ерөнхий журналын цалингийн зардлын дүнтэй тулган шалгахад 163,156.6 мянган төгрөгөөр дутуу байна.
- Тайлант онд хөгжлийн бэрхшээлтэй нэг ажилтнаас хувь хүний орлогын албан татварыг чөлөөлөөгүй улмаас 1,512.6 мянган төгрөгийг цалингаас илүү суутгасан байна.
- Сангийн яамны 2023 оны 01 дүгээр сарын 05-ны өдрийн 10/84 дүгээр албан бичгийн дагуу Гүйцэтгэл, үр дүнгээр санхүүжих байгууллагын санхүүгийн тайланг орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчийн тайлангаас улсын төсвийн ерөнхийлөн захирагчийн тайланд шилжүүлэхтэй холбоотой санхүүгийн байдал, үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайланд тус тус 5,481,763.5 мянган төгрөгийг Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.2-т “Нягтлан бодох бүртгэлийн алдааг алдаа гарсан үеийн санхүүгийн тайланд тусгах замаар залруулна” гэж заасныг үндэслэн санхүүгийн тайланд залруулсан.

Аудитаар нийт 16,027.6 мянган төгрөгийн зөрчил[2] илэрснээс, 4,141.9 мянган төгрөгийн 3 төлбөрийн акт тогтоож, 11,885.7 мянган төгрөгийн 3 зөвлөмж өгсөн.

### 5.1 Төлбөрийн акт

1. Тайлант оны цалин хөлсийг давтан тооцоолоход давхар ажил хөдөлмөр эрхэлдэг 3 ажилтанд 195.7 мянган төгрөгийн татварын хөнгөлөлт тооцсон байна. Энэ нь Хувь хүний орлогын албан татварын тухай хуулийн 23 дугаар зүйлийн 23.1-т "Албан татвар төлөгчийн энэ хуулийн 7.1.1, 7.1.2, 7.1.3, 7.1.4, 7.1.5, 7.1.7-д заасан орлогод ногдуулах жилийн албан татварт дараах хэмжээгээр албан татварын хөнгөлөлт эдлүүлнэ", 25 дугаар зүйлийн 25.5-т "Суутган төлөгч нь албан татвар төлөгчид энэ хуулийн 23.1-д заасан хөнгөлөлтийг эдлүүлэхдээ тус хэсэгт заасан албан татвар ногдуулах орлого болон хөнгөлөлтийг 12 сард тэнцүү хувааж, сар бүр эдлүүлнэ." гэж заасантай нийцэхгүй, санхүүгийн тайлагналын нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй.

**Шийдвэрлэсэн нь:** Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалын хавсралт “Акт албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам”-ын 4.2.3.3-т “Цалин хөлс, шагнал урамшуулал, тэтгэмжийг зөрүүтэй тооцож олгосон” гэж заасныг үндэслэн төлбөрийн акт тогтоосон.

2. Тайлант оны 1 дүгээр сард 91 ажилтанд 3,756.0 мянган төгрөгийн хоолны олговор олгосон байна. Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1-т "Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн, зөв гаргах үндэслэл болно.", Хөдөлмөрийн тухай хуулийн 122 дугаар зүйлийн 122.1-т "Ажил олгогч ажилтны төлөөлөгчийн саналыг харгалзан хууль тогтоомжид нийцүүлэн тухайн аж ахуйн нэгж, байгууллагын хэмжээнд үйлчлэх хөдөлмөрийн дотоод журмыг баталж мөрдүүлнэ." гэж заасантай нийцэхгүй, санхүүгийн тайлагналын нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

[1] Мэдээллийг тусгахгүй орхигдуулах, буруу тусган илэрхийлэх, үүнд, математик үйлдлийн алдаа, НББ-ийн бодлогыг мөрдөхөд гарсан алдаа, бодит байдлыг буруу тайлбарласан /буруу ойлгосон/, хайнга хандсан /мартсан, тэмдэглээгүй орхисон/,

[2] Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

**Шийдвэрлэсэн нь:** Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалын хавсралт “Акт албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам”-ын 4.2.3.3-т “Цалин хөлс, шагнал урамшуулал, тэтгэмжийг зөрүүтэй тооцож олгосон” гэж заасныг үндэслэн төлбөрийн акт тогтоосон.

3. Тайлант оны эцэст хувь хүний орлогын албан татварын хөнгөлөлтийн зөрүүг тооцоогүй улмаас 32 ажилтанд 190.2 мянган төгрөгийн татварын хөнгөлөлтийг илүү тооцож олгосон байна. Энэ нь Татварын ерөнхий газрын 2019 оны А/261 тоот тушаалын хавсралтын 4.4.1-т "Тухайн тайлант жилийн 12 сард бүрэн тухайн байгууллагад харьяалагдаж ажилласан ажилтанд Хувь хүний орлогын албан татварын тухай хуулийн 23.1-д заасан хөнгөлөгдөх татварын хэмжээг мөн хуулийн 27.1-д заасны дагуу жилийн эцэст өссөн дүнгээр тооцож, зөрүүг залруулж тайлагнана.", 4.4.2-т "Тайлант жилийн 12 сарын турш тухайн байгууллагад харьяалагдаж ажиллаагүй ажилтныг Хувь хүний орлогын албан татварын тухай хуулийн 23.1-д заасан хөнгөлөгдөх татварын хэмжээг суутгагч өссөн дүнгээр тооцох, зөрүүг залруулах үүрэг хүлээхгүй." гэж заасантай нийцэхгүй, санхүүгийн тайлагналын нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

**Шийдвэрлэсэн нь:** Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалын хавсралт “Акт албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам”-ын 4.2.3.3-т “Цалин хөлс, шагнал урамшуулал, тэтгэмжийг зөрүүтэй тооцож олгосон” гэж заасныг үндэслэн төлбөрийн акт тогтоосон.

**5.2 Зөвлөмж**

1. Нягтлан бодох бүртгэлтэй холбоотой асуудал

Байгууллагын мөрдөж буй НБББББ нь шинэчлэн батлагдсан УСНББОУС, хууль, тогтоол, тушаал зааврудыг тусгаагүй, байгууллагын удирдлагын тушаал шийдвэрээр батлаагүй байна. Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.9-д "Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг" гэж бүртгэлийн суурь, санхүүгийн тайлан гаргахад баримтлах зарчмыг тодорхойлсон журам, заавар, аргачлалыг багтаасан баримт бичгийг", 18 дугаар зүйлийн 18.2-т "Аж ахуйн нэгж, байгууллагын удирдлага нь нягтлан бодох бүртгэлийн хууль тогтоомж, стандарт, дүрэм, журам, зааварт нийцүүлэн нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг баталж, мөрдөж ажиллана", 20 дугаар зүйлийн 20.2.2-т “Аж ахуйн нэгж, байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг боловсруулах, батлуулах, хэрэгжилтийг зохион байгуулах" гэж заасныг тус тус мөрдөөгүй байна.

***<u>Өгсөн зөвлөмж:</u>***

НБББББ-ийг стандарт, хууль, тогтоомж, тушаал, заавар, дүрэм журамд нийцүүлэн шинэчлэн боловсруулж, баталж мөрдөж ажиллах зөвлөмж өгөв.

2. Нягтлан бодох бүртгэлтэй холбоотой асуудал

Багшийн хөгжил имидж төвд гэрээгээр "багш нарын танхимын сургалтад" 6,742.0 мянган төгрөг, музей үзүүлэх автобусны түрээсэнд 3,284.7 мянган төгрөгийг төлсөн байна. Энэ нь Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.2.3-т “сургалт, семинар, хурал, зөвлөгөөнийг цахим хэлбэрээр зохион байгуулж, бичиг хэрэг, тээвэр шатахуун, дотоод албан томилолт болон холбогдох бусад зардлыг хэмнэх", Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1-т "Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн, зөв гаргах үндэслэл болно.", Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-т "Төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах" гэж заасантай нийцэхгүй, санхүүгийн тайлагналын нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

***<u>Өгсөн зөвлөмж:</u>***

Санхүүгийн баримтын иж бүрдлийг хангаж ажиллах зөвлөмж өгөв.

3.Цалин хөлстэй холбоотой асуудал

Тайлант онд цалингийн зөрүү цэсэд алдааны залруулга хийхдээ анхан шатны баримтгүйгээр 3,859.0 мянган төгрөгийн залруулга хийсэн байна. Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1-т "Аж ахуйн нэгж, байгууллагын нягтлан бодох бүртгэл хөтлөлтөд гарсан алдааг алдаа гарсан шалтгаан, залруулах аргыг тодорхой тусгасан баримт, тайланг үндэслэн залруулах бөгөөд зөвшөөрсөн болон залруулга хийсэн албан тушаалтан гарын үсэг зурж баталгаажуулна." Гэж заасантай нийцэхгүй санхүүгийн тайлагналын нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

***<u>Өгсөн зөвлөмж:</u>***

Гүйлгээ бүрт анхан шатны баримтыг бүрдүүлж ажиллах.

Дээрх акт, албан шаардлага, зөвлөмжийн биелэлтийг Төв аймаг дахь Төрийн аудитын газарт 2023 оны 6 дугаар сарын 15-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

## 6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

### Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

*/мянган төгрөгөөр/*

| Алдааны товч утга | Нийт алдаа | | Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан | | Буруу тусган илэрхийлсэн | | Үүнээс | | | | Зөвлөмж | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | Залруулсан | | Залруулаагүй | | | |
| | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн |
| Мөнгөн хөрөнгөнөөс 6 ажил гүйлгээгээр 8,979.5 мянган төгрөгийг шилжүүлэхдээ тооцооны дансаар дамжуулалгүй шууд зардалд бичиж хаасан байна. | 1 | 626.4 | 1 | 626.4 | | | 1 | 8,979.5 | | | | |
| Төсвийн гүйцэтгэлийн тайланд суралцагчдын тоог тайлагнаагүй байна. | 1 | - | 1 | | | | 1 | - | | | | |
| Цалин хөлсний дэлгэрэнгүй бүртгэлийг ерөнхий журналын цалингийн зардлын дүнтэй тулган шалгахад 163,156.6 мянган төгрөгөөр дутуу байна. | 1 | 163,156.7 | | | 1 | 163,156.7 | 1 | 163,156.7 | | | | |
| Тайлант онд хөгжлийн бэрхшээлтэй нэг ажилтнаас хувь хүний орлогын албан татварыг чөлөөлөөгүй улмаас 1,512.6 мянган төгрөгийг цалингаас илүү суутгасан байна. | 1 | 1,512.6 | | | 1 | 1,512.6 | 1 | 1,512.6 | | | | |
| Сангийн яамны 2023 оны 01 дүгээр сарын 05-ны өдрийн 10/84 дүгээр албан бичгийн дагуу гүйцэтгэл, үр дүнгээр санхүүжих байгууллагын санхүүгийн тайланг орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчийн тайлангаас улсын төсвийн ерөнхийлөн захирагчийн тайланд шилжүүлэхтэй холбоотой санхүүгийн байдал, үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайланд тус тус 5,481,763.5 мянган төгрөгийг залруулаагүй байна. | 1 | 5,481,763.5 | 1 | 5,481,763.5 | | | 1 | 5,481,763.5 | | | | |
| **Дүн** | **5** | **5,647,059.2** | **3** | **5,482,389.9** | **2** | **164,669.3** | **5** | **5,655,412.3** | **-** | **-** | **-** | **-** |

## Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

*/мянган төгрөгөөр/*

| Зөрчлийн товч утга | Нийт зөрчил | | Үүнээс | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | Төлбөрийн акт | | Албан шаардлага | | Зөвлөмж | | Хариуцлага тооцуулах албан шаардлага | | Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал | |
| | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Албан тушаалтны тоо | Тоо | Дүн |
| Байгууллагын мөрдөж буй НБББББ-нь шинэчлэн батлагдсан УСНББОУС, хууль, тогтоол, тушаал заавруудыг тусгаагүй , байгууллагын удирдлагын тушаал шийдвэрээр батлаагүй байна. | 1 | - | | | | | 1 | - | | | | |
| Багшийн хөгжил имидж төвд гэрээгээр "багш нарын танхимын сургалтад" 6,742.0 мянган төгрөг, музей үзүүлэх автобусны түрээсэнд 3,284.7 мянган төгрөгийг төлсөн байна. /Хэдэн хүүхэд хаана юу үзсэнийг нотлох баримт байхгүй/ | 1 | 10,026.7 | | | | | 1 | 10,026.7 | | | | |
| Тайлант оны цалин хөлсийг давтан тооцоолоход давхар ажил хөдөлмөр эрхэлдэг 3 ажилтанд 195.7 мянган төгрөгийн татварын хөнгөлөлт тооцсон байна. | 1 | 195.7 | 1 | 195.7 | | | | | | | | |
| Тайлант оны 1 дүгээр сард 91 ажилтанд 3,756.0 мянган төгрөгийн хоолны олговор олгосон байна. | 1 | 3,756.0 | 1 | 3,756.0 | | | | | | | | |
| Тайлант онд цалингийн зөрүү цэсэд алдааны залруулга хийхдээ анхан шатны баримтгүйгээр 3,859.0 мянган төгрөгийн залруулга хийсэн байна. | 1 | 3,859.0 | | | | | 1 | 3,859.0 | | | | |
| Тайлант оны эцэст хувь хүний орлогын албан татварын хөнгөлөлтийн зөрүүг тооцоогүй улмаас 32 ажилтанд 190.2 мянган төгрөгийг илүү татварын хөнгөлөлтийг эдлүүлсэн байна. | 1 | 190.2 | 1 | 190.2 | | | | | | | | |
| **Дүн** | **6** | **16,027.6** | **3** | **4,141.9** | | | **3** | **11,885.7** | | | | |

## Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

*/мянган төгрөгөөр/*

| Зөрчлийн товч утга | Нийт зөрчил | | Үүнээс | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | Төлбөрийн акт | | Албан шаардлага | | Зөвлөмж | |
| | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн |
| Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил | | | | | | | | |
| Шилэн дансны цахим хуудсыг шалгахад 156 мэдээлэл байршуулахаас 145 мэдээлэл хугацаанд нь байршуулж, 11 мэдээллийг хугацаа хоцроож, Цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий 1 удаагийн 148,265,100.00 төгрөгийн орлогын гүйлгээг 173,356.7 мянган төгрөгөөр буюу 25,091.6 мянган төгрөгөөр илүү, 1 удаагийн 19,560.6 мянган төгрөгийн зарлагын гүйлгээг 21,991.9 мянган төгрөгөөр буюу 2,431.3 мянган төгрөгөөр илүү, 1 удаагийн 46,717.3 мянган төгрөгийн орлогын гүйлгээг 20,717.3 мянган төгрөгөөр буюу 26,000.0 мянган төгрөгөөр дутуу байршуулж, 4 удаагийн 117,752.3 мянган төгрөгийн орлого, 6 удаагийн 120,906.9 мянган төгрөгийн зарлагын гүйлгээг байршуулаагүй, ... хөрөнгө, мөнгө зарцуулах, ... 19 удаагийн 155,948.9 мянган төгрөгийн шийдвэрийг шилэн дансны цахим хуудсанд байршуулаагүй байна. | 1 | 448,131.0 | | | 1 | 448,131.0 | | |
| **Дүн** | **1** | **448,131.0** | | | **1** | **448,131.0** | | |
| Бусад хууль тогтоомжтой холбоотой зөрчил | | | | | | | | |
| 2022 онд хийгдсэн дотоод аудитын үйл ажиллагаа нь зөвхөн сургалтын үйл ажиллагаанд чиглэгдсэн, санхүү, шилэн данс , нягтлан бодох бүртгэл, төсвийн тухай, төрийн болон орон нутгийн өмчийн тухай, төрийн хэмнэлтийн тухай хууль тогтоомжийн хэрэгжилтэд хяналт хийдэггүй, санхүүгийн мэргэжлийн ажилтан дотоод хяналтын ажлын хэсгийн бүрэлдэхүүнд томилогдоогүй, ажилтнууд нь дотоод хяналтын талаар сургалтад хамрагдаагүй, дотоод хяналтын талаар зохих мэдлэг эзэмшээгүй, дотоод хяналтын ажиллах журамгүй байна. | 1 | - | | | | | 1 | - |
| Гүйцэтгэлд суурилсан төсвийг цөөн нэр төрлөөр баталснаас шалтгаалж, тээвэр шатахуун, томилолт, сургалт, хөрөнгө бэлтгэх зэрэг зардлуудыг Сангийн сайдын 2021 оны 190 дугээр тушаалаар баталсан зардлын ангилал, дансаар ангилж бүртгээгүй, санхүүгийн тайлангийн үзүүлэлтээр тайлагнаагүй байна. | 1 | - | | | 1 | - | | |
| Шалгагдагч байгууллагын худалдан авсан хөрөнгө, материалын дүнг, бэлтгэн нийлүүлэгч байгууллагуудын төлбөрийн цахим системд бүртгэсэн дүнтэй тулгахад 9 иргэн, байгууллагын 2,901.8 мянган төгрөгөөр илүү, 2 иргэн, байгууллагын 774.4 мянган төгрөгөөр дутуу байна. | 1 | 3,676.1 | | | | | 1 | 3,676.1 |
| Хүүхдийн хоол хүнсний материалаас хэмнэгдсэн төсвийн үлдэгдэл 1,453.7 мянган төгрөгийг нөөцөлсөн байна. | 1 | 1,453.7 | | | 1 | 1,453.7 | | |
| **Дүн** | **4** | **5,129.8** | | | 2 | 1,453.7 | **2** | **3,676.1** |
| **Нийт дүн** | **5** | **453,260.8** | | | **3** | **449,584.7** | **2** | **3,676.1** |